Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Коронавируст халдвар (covid-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”-ын 10 дугаар хавсралт “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ”;
- Засгийн газрын 2020 оны 78 дугаар тогтоолоор баталсан Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай;
- Засгийн газрын 2020 оны 98 дугаар тогтоолоор баталсан Эрүүл мэндийн сургалт, эрдэм шинжилгээний зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай;
- Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоолоор баталсан Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай;
- Засгийн газрын 2020 оны 168 дугаар тогтоолоор баталсан Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай;
- Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолоор баталсан Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай;

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Эрүүл мэндийн хөгжлийн төв санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь Эрүүл мэндийн яамнаас 2010 онд боловсруулсан Эрүүл мэндийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Уг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын онцлогт тохироогүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжийн өөрчлөлтийг бүрэн тусгаагүй байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 5,817,254.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 58,172.5 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,366,399.5 мянган төгрөгөөр буюу 108.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	260.0	260.0
Авлага	-	1,394,033.9	1,394,033.9
Урьдчилгаа		72,000.0	72,000.0
Бараа материал	151,014.8	1,167,414.4	1,016,399.6
Үндсэн хөрөнгө	2,050,124.4	2,005,830.4	(44,294.0)
Нийт хөрөнгө	2,201,139.2	4,639,538.7	2,438,399.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,201,139.2	4,639,538.7	2,438,399.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,201,139.2	4,639,538.7	2,438,399.5

Авлага дансны үлдэгдэл 1,394,033.9 мянган төгрөг нь Коронавируст халдвар (covid-19) цар тахлын эрсдэлээс хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийг дэмжих төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авалтын 6 багц ажлын санхүүжилт 442,475.0 мянган төгрөг, салбарын хүний нөөцийн мэдээний сангийн программ хангамжийг хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний төлбөр 200,000.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлсэн үлдэгдэл 751,558.9 мянган төгрөг байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 72,000.0 мянган төгрөг нь Эрүүл мэндийн ажилтнуудад ажлын байран дээр “Халдвар, хамгааллын дэглэм баримтлах, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” сэдвээр дадлага, сургуулилтыг цахим хэлбэрээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх” ажлын урьдчилгаа санхүүжилт байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,167,414.4 мянган төгрөг болж 1,016,399.6 мянган төгрөгөөр өссөн нь Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд зориулж Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Онцгой байдлын ерөнхий газар болон бусад аж ахуйн нэгж, иргэдээс хандив тусламжаар ирсэн тусгаарлан ажиглах байранд ажиллаж байгаа резидент эмч нарт олгох нэг удаагийн хамгаалах хувцас хэрэглэл, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Оны эцэст 354,824.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй, 48,527.3 мянган төгрөгийн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу тусгай үүргийн онгоцоор эх орондоо ирж байгаа иргэдийн тусгаарлан ажиглах байр хариуцан ажиллаж байгаа резидент эмч нарт олгох нэг удаагийн хамгаалах хувцас хэрэглэл, эм, эмнэлгийн материал байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,639,538.7 мянган төгрөг болж 2,438,399.5 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагаас авах авлага болон бараа материал дансны үлдэгдэл материаллаг хэмжээгээр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 5,062,571.5 мянган төгрөгөөр буюу 87.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан дараах орлогууд байна. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны орлого- 318,570.0 мянган төгрөг;

- Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого- 1,630,451.9 мянган төгрөг;
- Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө- 1,766,212.0 мянган төгрөг;
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого- 702,724.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого нь эм ханган нийлүүлэх байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгсэл бүртгүүлэх бүртгэлийн тоо нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 1,632,635.5 мянган төгрөгөөр буюу 28.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлууд байна. Энэ нь Эрүүл мэндийн яамнаас олгосон Коронавируст халдвар (covid-19) цар тахлын голомтот тусгаарлан ажиглах байр хариуцан ажилласан резидент эмч нарын урамшуулал, Эрүүл мэндийн сайдын А/432 дугаар тушаалаар цар тахлын үед ажилласан эмч, эмнэлгийн ажилчдын ар гэрт олгосон дэмжлэг, Засгийн газрын 179 дүгээр тогтоолоор цар тахлын голомтот бүсэд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилчдад олгосон урамшууллын зардлууд байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 7,075,238.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 461,222.8 мянган төгрөгөөр бууруулж 6,614,015.8 мянган төгрөгөөр баталсан байна. Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих эх үүсвэрийг 565,000.0 мянган төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 2020 оны 06 дугаар сард 770,970.7 мянга, 08 дугаар сард 885,748.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Дээд шатны байгууллагад хүргүүлсэн төсвийн төслийн саналаас 461,222.8 мянган төгрөгийг бууруулж баталсан, мөн төсвийн гүйцэтгэлээр тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны орлогыг 2 удаа нэмэгдүүлэн баталсан, 51,753.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн нь төсвийн төлөвлөлтийг бодитой боловсруулаагүй байгааг харуулж байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,614,015.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 5,628,267.2 мянган төгрөгийг улсын төсвөөс 885,748.6 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос 100,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,628,267.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1,003,126.0 мянган төгрөг, нийт 6,631,393.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 6,579,639.5 мянган төгрөгийг зарцуулж 51,753.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.5 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардалд 8,388.5 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 25,967.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 50,672.9 мянган төгрөгөөр, нэг удаагийн, шагнал урамшуулал арга хэмжээ 978.7 мянган төгрөгөөр, гэрээт ажиллагсдын зардал арга хэмжээ 93.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 64,518.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 1,813,112.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 733,631.0 мянга, нийт 2,611,261.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, үйлчилгээний зардалд 1,028,826.1 мянга, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардалд 830,876.0 мянга, нийт 1,859,702.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 751,558.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 107 мэдээллээс хугацаандаа оруулсан 101 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл, 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 12,590.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 43,471.3 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 96.0 хувьтай байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны үзүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	12,590.0	1	12,590.0			
Зөвлөмж	5	43,471.3	5	43,471.3			
Нийт дүн	6	56,061.3	6	56,061.3			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 333,682.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 296,678.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 37,003.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлжээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны А-1/791 "Зөвшөөрөл олгох тухай" албан бичигт Эрүүл мэндийн яамны харьяа төрийн өмчийн хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн данснаас эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэх 4,768.1 мянган төгрөгийн номыг бараа материал дансанд бүртгэж тайлагнаагүйг;
2. Нэмэлт санхүүжилтийн данснаас Эрүүл мэндийн ажилтнуудад "Халдвар хамгааллын дэглэм баримтлах, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сэдвээр, дадлага сургуулилтыг цахим хэлбэрээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх" ажлын урьдчилгаа санхүүжилтийг гэрээний дагуу 90 хувийг олгож шууд зардлаар бүртгэснийг;
3. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн нэгдсэн мэдээний сангийн программ хангамжийг хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний санхүүжилтийг гэрээний дагуу бүрэн олгож шууд зардлаар хүлээн зөвшөөрч, тооцооны данс бүртгэлд тусгаагүйг аудитын явцад залруулав.
4. Ажилчдад ажлын үр дүнгээр тооцон урамшуулал олгохдоо Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-д заасан ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамаарах хувь хэмжээнд ногдох хувиар тооцоогүй, илүү дүнгээр тооцож олгосон талаар завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 37,003.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 37,003.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ . Үүнд:

1. Мэргэжлийн хяналтын байцаагчийн 2015 оны 02-07-94/1425 дугаартай захиргааны актаар цаашид ашиглах боломжгүй болохыг тодорхойлсон барилгыг резидент эмч нарын дотуур байр, сургалт, судалгааны төвийн зориулалтаар ашиглаж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулж холбогдох газарт оруулна", Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.5 "барилга байгууламжийг галын аюулаас урьдчилан сэргийлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн болон экологийн шаардлагыг хангуулах", 46.1.14-д "барилга байгууламжийн ашиглалтын хугацааны 15 жил тутамд барилга, байгууламжийн төлөв байдалд барилгын улсын хяналтын асуудал эрхэлсэн байгууллагаар дүгнэлт гаргуулж, холбогдох арга хэмжээг авах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

2. Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй аж ахуйн зориулалттай 31,635.3 мянган төгрөгийн балансын үнэтэй, 977 м.кв хэмжээтэй газрыг хувь хүнд үнэ төлбөргүй ашиглуулж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 "төрийн өмчит хуулийн этгээд өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана", газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.2-т газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

3. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 181/ШШ2019/2526 дугаартай шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговрын 5,368.5 мянган төгрөгийг байгууллагаас олгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Коронавируст халдвар (сovid-19) цар тахлын улмаас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор ажлын тусгай горимоор ажилласан нь аудитыг гүйцэтгэх үе шатанд анхан шатны баримтуудыг хамруулах, тайлбар тодруулга авах, үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд түүвэр тооллого хийх зэрэг биет горим сорил хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.25	Аудитын нэр: Төсвийн шууд захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/60/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Эрүүл мэндийн хөгжлийн төв	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Мэргэжлийн хяналтын байцаагчийн 2015 оны 02-07-94/1425 дугаартай захиргааны актаар цаашид ашиглах боломжгүй болохыг тодорхойлсон барилгыг Эрүүл мэндийн хөгжлийн төв нь резидент эмч нарын дотуур байр, сургалт, судалгааны төвийн зориулалтаар ашиглаж байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Захирал Ахлах нягтлан бодогч	Б.Нарантуяа Б.Очир
2	Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй аж ахуйн зориулалттай 31,635.3 мянган төгрөгийн балансын үнэтэй, 977 м.кв хэмжээтэй газрыг хувь хүнд үнэ төлбөргүй ашиглуулж байна.	31,635.3	Албан шаардлага хүргүүлэх	Захирал Ахлах нягтлан бодогч	Б.Нарантуяа Б.Очир
3	Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 181/ШШ2019/2526 дугаартай шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговор олгосон.	5,368.5	Албан шаардлага хүргүүлэх	Захирал Ахлах нягтлан бодогч	Б.Нарантуяа Б.Очир
ДҮН		37,003.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 53/АД170079

Улаанбаатар хот

САГ-2021/60/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй аж ахуйн зориулалттай 31,635,260.00 (Гучин нэгэн сая зургаан зуун гучин таван мянга хоёр зуун жар) төгрөгийн балансын үнэтэй, 977 (есөн зуун далан долоо) м.кв хэмжээтэй газрыг хувь хүнд үнэ төлбөргүй ашиглуулж байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 “төрийн өмчит хуулийн этгээд өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана”, Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.2 “газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Газрын тухай хууль тогтоомжийн дагуу төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг хуульд заасан зориулалтын дагуу эзэмших, ашиглалтыг сайжруулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал Б.Нарантуяа, ахлах нягтлан бодогч Б.Очир нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
П.АМАРСАНАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 54/АО170078

Улаанбаатар хот

САГ-2021/69/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь цаашид ашиглах боломжгүй болохыг тодорхойлсон барилгыг резидент эмч нарын дотуур байр, сургалт, судалгааны төвийн зориулалтаар ашиглаж байна.

Энэ нь Мэргэжлийн хяналтын байцаагчийн 2015 оны 02-07-94/1425 дугаартай захиргааны акт, Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.5 "барилга байгууламжийг галын аюулаас урьдчилан сэргийлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн болон экологийн шаардлагыг хангуулах", 46.1.14-д "барилга байгууламжийн ашиглалтын хугацааны 15 жил тутамд барилга, байгууламжийн төлөв байдалд барилгын улсын хяналтын асуудал эрхэлсэн байгууллагаар дүгнэлт гаргуулж, холбогдох арга хэмжээг авах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгийн эрүүл ахуй, аюулгүй байдал алдагдсан бодит нөхцөл байдлыг харгалзан хөрөнгө оруулалт, их засварын асуудлаар санал боловсруулж холбогдох газарт хүргүүлж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал Б.Нарантуяа, ахлах нягтлан бодогч Б.Очир нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР
П.АМАРСАНАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 55/АД/20079

Улаанбаатар хот

СЭГ-2021/60/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 181/ШШ2019/2526 дугаартай шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговрын 5,368,540.00 (таван сая гурван жаран найман мянга таван зуун дөч) төгрөгийг байгууллагаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр ажилдаа эргэж орсон албан хаагчид олгосон 5,368,540 төгрөгийн төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллан, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал Б.Нарантуяа, ахлах нягтлан бодогч Б.Очир нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР
П.АМАРСАНАА

